

“ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ ХИЧЭЭЛИЙГ ЗААХАД ТУЛГАРСАН СОРИЛ, ҮР ДҮН, БА САНАЛ: ‘ОУХ-НЫ ҮНДЭС БА ДАЯАРШИЛ’ ХИЧЭЭЛИЙН ЖИШЭЭН ДЭЭР ХИЙСЭН СУДАЛГАА”

*Д.Бүдсүрэн**

***Abstract:** The vision of the National University of Mongolia has been defined to be a nationally research-oriented model-university, inspiring the Mongolia's further progress that is fully consistent with the world standards. In this sense, the top priority of the NUM is to prepare nationwide cadres and experts who manage to valuably contribute to the development of the country by disseminating newly created knowledge, competitive in the world in the fields of natural, social, humanitarian and technological sciences. So I have thrived to share my own experiences teaching IR lessons from the constructivist point of view by enriching the lesson contents in consistence with world standards; re-designing a course syllabus and pragmatically conducting seminar lessons based upon the knowledge creation; and to expose how this helps improve students' skills and abilities as it is our main duty to proactively and effectively convey the knowledge to students aimed at this priority. Thus, I have made analyses on a respective survey from 81 students out of 145 (55.86%) in the fall semester, and from 60 students out of 116 in the spring semester.*

***Key words:** International Relations, Globalization, Teaching, and Research-Based Proactive Learning*

Дэлхийн хоёрдугаар дайны дараа олон улсын харилцаа нь нэгэн шинэ академик судлагдахуун болж бүрэлдэн тогтсоноор түүнийг хэрхэн заах вэ гэдэг асуудал хурцаар тавигдаж ирсэн. Олон улсын харилцааг хэрхэн заах арга зүйн аргачлалуудыг судлах ажил ХХ зууны сүүл, ХХI зууны эхэн үеэс эхэлж эрдэмтэд бүтээл туурвилаа гаргаж эхэлсэн байдаг. Хэдий зарим эрдэмтдийн хувьд олон улсын харилцааг заах өөр өөрийн арга барилыг хувийн туршлага дээр үндэслэн судалгааны ажилдаа тусгасан байдаг ч нөгөө хэсэг эрдэмтдийн хувьд заах арга зүй болон суралцах хоёрын харилцан үйлчлэлийг шинжлэх ухааны аргачлалаар нотолж өөрсдийн бүтээлээр хувь нэмэр оруулахыг зорьсон байдаг. Эдгээр эрдэмтдийн бүтээлээс үзэхэд заах арга зүй болон суралцах арга зүйн харилцан үйлчлэлийг харгалзан багш хувийн хичээл заасан туршлага дээр үндэслэн судалгаа хийх нь хамгийн үр дүнтэйд тооцогддог. Өөрөөр хэлбэл дээрх эрдэмтдийн аргыг хооронд

* МУИС, ОУХНУС, ОУХТ-ийн ахлах багш, докторант

нь хослуулсан байдлаар өөрийн судалгааг хийж тодорхой үр дүн гаргахыг хичээлээ.

Америкийн нэрт улс төрч, антропологич Жон Баллок хэлэхдээ “Хүүхэд бүрт хичээл заах нь чухал биш, хүүхэд бүрийг сурах хүсэлтэй болгох нь илүү чухал” гэсэн байдаг. Тэгвэл оюутан бүрийг хэрхэн сурах хүсэлтэй болгох вэ гэдэг нь хичээлийг ямар аргаар зохион байгуулах эсэхээс хамаарч оюутнуудыг сурах сэдлийг төрүүлэх буюу сэдэлжүүлэх (to motivate in eng.) үйл явц эхэлнэ. Уг хичээлийг судлахаар сонгосон оюутны сонголтоос хамаарч 1 улиралд ойролцоогоор 5 семинарын анги үүсдэг ба 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улиралд 27-30, хаврын улиралд 22-24 оюутны дүүргэлтэй байдаг. “ОУХ-ны Үндэс ба Даяаршил” хичээлийн лекцийн агуулгыг оюутнуудад олон улсын харилцаа, олон улсын эдийн засгийн харилцаа, олон улсын улс төрийн эдийн засаг, олон улсын эрх зүй, олон улсын аюулгүй байдал болон олон улсын байгууллага зэрэг үндсэн ухагдахууныг дотор нь хэд хэдэн дэд хэсгүүдэд задалж, долоо хоног тутамд нэг сэдэв нийт 16 сэдэв судлахаар хичээлийн хөтөлбөрт тусгагдсан байдаг ба нийт оюутнуудыг хичээлд идэвхитэй оролцуулж сэдэлжүүлэхийн тулд семинар хичээлийн хүрээнд дараах алхамуудыг хийв. Үүнд:

1. Оюутнуудад хичээлийн бус цагаар богино хэмжээний видео кино үзүүлж хичээлээр олж авсан онолын мэдлэгийг практик үйл ажиллагаагаар бататгах;
2. Нийт оюутнуудыг улирлын туршид 1-2 удаа дүрд (role-play simulation) тоглох эсвэл тоглоом тоглуулах (асуулт хариулт тэмцээн зохиох),
3. Нийт семинарын анги бүрийн оюутныг 2-3 оюутан тус бүрээр баг болгон хуваарилж, олон улсын харилцаанд өмнө нь болсон, одоо болж буй үйл явдалд үндэслэн тодорхой нэгэн кейс-судалгаа хийж үр дүнгээ танилцуулах даалгавар өгдөг;
4. Улирлын явцад оюутан тус бүр өөрийн сонирхолд нийцсэн 1 сэдвийг сонгон авч нэг удаадаа (1 сард 1 удаа нийт 3 удаа эссэ бичих) 1-3 хуудас эссэ бичих даалгаврыг авснаар оюутан бие даан өөрийн сонирхлын хүрээнд тодорхой нэг асуудлыг (Америк-Хятадын хооронд худалдааны дайн гарах болсон улс төр, эдийн засгийн шалтгаан юу вэ гэх мэт) гүнзгийрүүлэн судлах боломжтой болдог. Мөн хуучин сургалт явуулахад өргөн хэрэглэгддэг байсан реферат бичиж дүн авах аргыг арай боловсронгуй хэлбэрээр буюу оюутанд хүндрэл учруулахгүйгээр цөөн хуудсанд багтаан судалгааны үр дүнгээ бичиж дүгнүүлэх боломжийг олгохоос гадна багшийн хувьд оюутны эссэ бичих чадварыг хэрхэн сайжруулахад зөвлөгөө өгөх, оюутан тус бүрийн хичээлийн талаарх ойлголт хэр байгааг дүгнэх, дараагийн эссэ бичихэд юун дээр анхаарах зэргийг зөвлөхөд тустай;
5. Семинар хичээл бүр дээр нэг кейс-судалгааны баг тус бүр судалгааны үр дүнгээ ‘PPP’ хэлбэрээр танилцуулга бэлтгэн хүргэдэг бөгөөд судалгааны агуулга нь судалгааны зорилго, арга, аргачлал, үр дүн, дүгнэлт гэсэн

хэсгүүдээс бүрдэнэ. Дараа нь багууд урьдчилан бэлтгэж ирсэн 2-3 асуулт тавьж хэлэлцүүлэг семинар хичээл бүрээр өрнүүлдэг нь нэг талаар оюутнуудын тухайн сэдвээр олж авсан мэдлэгийг бататгах, нөгөө талаар оюутан бүрийн хэлэлцүүлэгт идэвхитэй оролцох сэдлийг хөхиүлэн дэмжиж идэвхийн оноо авах нөхцөл бүрдүүлдэг;

6. Кейс-судалгааны (case-study method) хүрээнд жишээ өгч асуудлыг шийдвэрлүүлэх (problem solving activity) арга нь онолын хичээлээр үзсэн мэдлэгийг практик үйл явдалд холбон тайлбарлах нөхцлийг бүрдүүлдэг;
7. Хамгийн сүүлд баг тус бүрт хийсэн судалгааны үр дүндээ үндэслэн 5-10 хуудас тайлан бичих даалгаврыг өгдөг ба судалгааны тайлан бичих тодорхой шаардлагуудыг баримтлахыг анхааруулж, тайлан бичихэд тавих шаардлагыг өмнө бичсэн жишиг тайлантай хамт оюутнуудад facebook болон микрософт teamz групп дээр урьдчилан байршуулдаг. Үүнд судалгааны тайлан бичих бүтэц, ишлэл зүүлт авах, эх сурвалжийг тодорхой тавьж өгөх, хуучин болон сүүлийн үеийн тоо баримт, датаг харьцуулан дүгнэлт гаргах, тодорхой нэг үсгийн фонт хэрэглэх, мөр хоорондын зай баримтлах, алдаагүй бичих зэргийг зөвлөдөг зэрэг олон үр дүнтэй аргыг семинар хичээлээ зохион байгуулах явцдаа хэрэглэдэг.

Онолын хувьд нийгмийн ухааны хичээлийг тэр дундаа олон улсын харилцааны мэргэжлийн хичээлийг идэвхитэй сургалтын аргууд буюу (active learning methods) практик-онолын харилцан шүтэлцээн дээр тулгуурлан хэлэлцүүлэг хийх, асуулт, хариулт байнга өрнүүлж мэтгэлцээн хийх, симуляци хийх (simulation in eng) буюу дүрд тоглуулах, кейс-судалгаан дээр ажиллуулах, оюутны мэдлэгийг үнэлэхдээ эссэ бичүүлж хичээлийн агуулгыг хэрхэн ойлгосныг хувиар дүгнэх зэрэг идэвхитэй хичээл явуулах интерактив аргуудыг хичээлдээ ашиглан оюутнуудыг сэдэлжүүлэхийг зорьж байна. Онолын суурь ухагдахуун талаасаа энэ нь конструктивист онолын сургуулиар тайлбарлагдах юм. Конструктивист онол нь оюутан зөвхөн багшийн өгсөн мэдээллийг идэвхигүй байдлаар тогтоох, цээжлэхээс илүүтэйгээр суралцагч нь шинэ түвшний мэдлэгийг бүтээхэд чиглэгдэнэ. Хүмүүс дэлхий ертөнцөд болж үйл явдлуудаас улбаалж өдөр тутамд шинэ шинэ туршлага хуримтлуулах, тэр туршлагадаа үндэслэн өмнө нь олж авсан мэдлэгээ дээрээ шинэ олж авсан мэдээллээ нэгтгэж өөр шинэ мэдлэг бүтээх боломжтой болдог гэсэн үг. Үүнийг хичээл заах уламжлалт хэв шинжтэй харьцуулж харвал:

№	Уламжлалт хэв шинж ба заах арга зүй	Конструктивист хэв шинж ба заах арга зүй
1.	Хичээлийн хөтөлбөр нь тусгайгаас бүхэл рүү, буюу жижиг хэсгүүдээс бүхэл рүү үндсэн чадваруудад тулгуурлах байдлаар заагдана.	Хичээлийн хөтөлбөр нь том үзэл баримтлалд суурилж ерөнхийгөөс тусгай руу, бүхлээс жижиг хэсгүүд рүү задрах байдлаар заагдана.
2.	Тогтсон хичээлийн хөтөлбөрийг баримтлахыг илүүд үзнэ.	Оюутны асуулт, ашиг сонирхол хамгийн түрүүнд үнэлэгдэнэ.
3.	Сургалтын материалууд ерөнхийдөө сурах бичгүүд, дасгал ажлын номнууд байна.	Хичээлд хэрэглэгдэх материалуудад анхдагч эх үүсвэрийн материалууд, ...

4.	Сургалт байнгын давтамжийн шинжтэй байна.	Сургалтын арга нь интерактив, оюутны аль хэдийн олж авсан мэдлэг дээр тулгуурлан явагдана.
5.	Багш нь оюутнуудад мэдээлэл түгээж, оюутан мэдлэг олж авна.	Багш оюутнуудтай харилцан ярилцаж оюутнуудад мэдлэг бүтээхэд нь туслах үүрэгтэй.
6.	Багшийн үүрэг захиргаадлын, захирангуй шинжтэй байна.	Багшийн үүрэг нь яриа хэлэлцээнд тулгуурласан мөн интерактив шинжтэй байна.
7.	Оюутны мэдлэгийг үнэлэхдээ зөвхөн тестээр болон зөв хариултанд үндэслэн дүгнэнэ.	Оюутны мэдлэгийг үнэлэхдээ оюутны гүйцэтгэсэн ажил, ажиглалтын үр дүн, үзэл бодол болон тестийн үр дүнд тулгуурлаж дүгнэнэ. Үйл явц нь үр дүнтэйгээ адил чухалд тооцогдоно.
8.	Мэдлэгийг хөдөлгөөнгүй, идэвхигүй шинжтэй гэж үзнэ.	Мэдлэг бол бидний туршлагаас үүдэн байнгын өөрчлөгдөж байдаг динамик шинжтэй байна.
9.	Оюутан ерөнхийдөө ганцаараа ажиллана.	Оюутнууд голдуу багаар ажиллана.

Эх сурвалж: <http://www.buffalo.edu/ubcei/enhance/learning/constructivism.html>

Конструктивист онолын үүднээс дүгнэхэд сургалт оюутан төвтэй, интерактив шинжтэй байх бөгөөд багш сургалтанд зааварлагч, захирагчийг үүргээр бус оюутныг шинэ мэдлэг олж авах, үйлдвэрлэхэд гол чиглүүлэгчийн үүрэгтэйгээр оролцох юм. Оюутнуудыг баг болгон ажиллуулж нэг нөгөөгөөсөө суралцах боломжийг олгохдоо өмнө нь олж авсан мэдлэг, мэдээлэл дээр нь үндэслэн яагаад, хэрхэн, ямар учраас гэсэн асуултуудыг голдуу асууж, суралцах, цаашид гүнзгийрүүлэн судлах суурийг тавьж оюутныг сэдэлжүүлэх нь багшийн зүгээс сургалтанд баримтлах гол чиглэл мөн. Оюутны мэдлэгийг үнэлэхдээ ганц зөв хариулттай тест авч мэдлэгийг дүгнэхээс илүүтэйгээр олон хариулттай байх тест зохиох, хариулт нь дийлэнхийн хариултаас өөр байх аваас багш яагаад гэдэг асуултыг өөртөө тавих нь зүйтэй. Боломжтой бол суралцагчаар бичил судалгаа хийлгэх, эссэ бичүүлэх зэрэг мэдлэг бүтээх олон аргаар дүгнэхийг хичээх хэрэгтэй. Учир нь хувь хүн бүрийн туршлагаас шалтгаалж мэдлэг тогтвортой бус динамик шинжтэй, байнгын хөдөлгөөнд оршиж шинэ тутам мэдлэг үүсэх боломжтой гэсэн байдлаар сургалтаа явуулах нь үр дүнтэй юм.


Энэхүү судалгааны ажлын хүрээнд миний бие МУИС-ийн бакалаврын хичээлийн сургалтын төлөвлөгөөний хүмүүнлэгийн ухааны ерөнхий суурь хичээлийн жагсаалтад багтсан “ОУХ-ны Үндэс ба Даяаршил” хичээлийг орчин үеийн заах арга зүйтэй уялдуулан хэрхэн илүү ойлгомжтой, үр дүнтэй, сонирхолтой хэлбэрээр оюутнуудад хүргэх вэ, энэ хичээлийг суралцахаар сонгосон байгаль, нийгэм, хүмүүнлэгийн салбарын оюутнуудыг цаашид гүнзгийрүүлэн суралцахад хэрхэн сэдэлжүүлэх вэ гэдгийг гол зорилго болгон 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улиралд өөрийн заасан уг хичээлийг судалгааныхаа объект болгон сонгон авч хичээлийн агуулга, явц, хичээл зохион байгуулах хэлбэр, оюутнуудын гэрийн даалгаврын гүйцэтгэл, энэ хичээлийн хүрээнд олж авсан мэдлэг чадвар, хандлага зэргийг ажиглан дүгнэлт гаргахыг зорьсон болно. Уг судалгааны үр дүнг тооцохдоо ажиглалтын арга, санал асуулга, харьцуулалт, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх зэрэг судалгааны аргуудыг өргөн ашигласан.

2020-2021 оны хичээлийн жилийн намрын улиралд уг хичээлийг нийт 145 оюутан, хаврын улиралд 116 оюутан тус тус судлахаар сонгосон. Намрын улирлын 92 (63.44%), хаврын улирлын 70 (60.34%) нийт 162 оюутан 20 асуулт бүхий нэргүй санал асуулгад оролцож, өөрсдийн санаа бодол, байр суурийг илэрхийлсэн болно. Цаашид энэхүү хичээлийн агуулгыг хэрхэн улам баяжуулах, энэ хичээлээр ямар чадвараа хөгжүүлсэн, цаашид оюутан өөрийн ямар чадварыг хөгжүүлэх шаардлагатай, судалгаа хийх чадварыг хөгжүүлэхэд багшийн зүгээс юунд түлхүү анхаарах, хичээлийн хүрээнд өгөгдөж буй зарим даалгавруудыг гүйцэтгэхэд оюутанд ямар хүндрэл учирч байгаа тухайлбал: эссэ бичихдээ хэрхэн бүтцийн талаас юуг анхаарах, кейс-судалгаан дээр багаар ажиллах, судалгааны үр дүнг илтгэх тайлан бичих зэрэгт тулгарч буй олон талын асуудлыг олж тогтоон, цааш цаашдын хичээлийг хэрхэн үр өгөөжтэй, оюутны эрэл хэрэгцээ шаардлагад нийцсэн, оюутны чадавхыг хөгжүүлэхэд чиглүүлж заах, ямар аргачлал, арга зүйг баримталвал сургалтын чанарыг дээшлүүлж болох зэрэг олон талын ач холбогдолтой мэдээллийг олж авлаа. Тиймээс судалгааныхаа бүтцийг нэгдүгээрт -- оюутны хөгжүүлсэн болон цаашид хөгжүүлвэл зохих чадварууд, хоёрдугаарт -- гэрийн даалгаврын гүйцэтгэл, гуравдугаарт -- хичээлийн агуулгын талаарх оюутны байр суурь гэсэн үндсэн гурван хэсэгт хуваан асуулгын үр дүнг боловсруулж нэгдсэн дүгнэлт хийхийг багшийн зүгээс зорьсон.

Судалгаанд нийт оролцогсдын 79.85% нь эмэгтэй, 20.15% хувь нь эрэгтэй оюутнууд бол насны хувьд дийлэнх нь буюу 162 оюутны 81 нь (47.8%) 16-18 насны нэгдүгээр түвшний оюутнууд, 79 (51.65%) 19-21 насны хоёр, гуравдугаар түвшний оюутнууд бол үлдсэн 0.45% нь тус бүр 1 хүн 22-24 насны, нөгөө 1 нь 24-өөс дээш насны оюутан байна.


1. Таны хүйс

92 responses




1. Таны хүйс

70 responses




2. Таны нас?

92 responses



2. Таны нас

70 responses



Суралцаж буй чиглэлийн хувьд асуулгад оролцсон 162 оюутны 108 нь (65.35%) нийгмийн, 30 нь (18.35%) байгалийн, 14 нь (9.65%) тус бүр хүмүүнлэг болон хэрэглээний шинжлэх ухааны чиглэлийн оюутнууд байна. Цаашид суралцах мэргэжлийн хувьд асуулгад оролцогсдоос эдийн засгийн чиглэлээр тэр дундаа олон улсын эдийн засаг, бизнесийн удирдлага, санхүү, нягтлан бодох бүртгэл, маркетинг, менежмент чиглэлээр нийт 46 буюу дийлэнх нь; олон улсын харилцаа, нийтийн удирдлагын суурь хөтөлбөрөөр 20 гаруй, нийгмийн ухааны бусад чиглэл социологи, сэтгэл судлалаар 10 орчим, хүмүүнлэгийн ухаан тэр дундаа гадаад хэл, соёл, орон судлалаар 12, компьютер, програм хангамжаар мөн 10 орчим, байгалийн ухааны чиглэлүүд болох биологи, биотехнологи, нано-технологи, экологи, инженерчлэл-10 орчим, одоогоор шийдээгүй байгаа хэмээн 10 орчим, мөн нийгэм, хүмүүнлэгийн гэсэн ерөнхий хариулт өгсөн 10 гаруй оюутан байна.

“ОУХ-ны Үндэс ба Даяаршил” нь бакалаврын түвшний оюутнууд дунд ерөнхий эрдмийн суурь хичээлүүд дундаас улиралд дунджаар 350-400 орчим оюутан судлахаар сонгодог хамгийн их хандалт авдаг хичээлүүдийн нэг мөн. Энэ утгаараа уг асуулгаар тус хичээлийг сонгох болсон гол шалтгааныг тодруулахад мэргэжлийн суурь хичээл тул заавал судлах ёстой; ОУХНУС руу суралцахаар шилжих хүсэлт гаргахаар төлөвлөж байгаа; сонирхолтой санагдсан; ОУХ, ОУЭЗХ-ны талаарх ерөнхий ойлголттой болох, гүнзгийрүүлэн судлах; улс орнуудын хоорондын харилцаа талаар ерөнхий мэдлэгээ өргөжүүлэх; дэлхий эргэн тойронд өрнөж буй үйл явдлын учир шалтгааныг ойлгох; даяаршлын талаар илүү сайн ойлголттой болох, даяаршлын онцлог, ач холбогдлыг танин мэдэх, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхахын тулд мэдлэг хуримтлуулах; ямар нэгэн шалтгаан байхгүй; эрэлт хэрэгцээ, шаардлагын улмаас; мөн зарим чадвараа хөгжүүлэх; санхүүгээ зохицуулж сурах; гадаад хэл, орон судлалын чиглэлээр сурч буй тул; найзууд санал болгосон зэргээр тус тус хариулжээ.

Үүнээс үзэхэд хүмүүнлэгийн ухааны ерөнхий суурь хичээлийн сонголтод байдаг уг хичээлийг зөвхөн олон улсын харилцааны чиглэлээр суралцаж буй оюутнуудын заавал судлах ёстой суурь хичээлийн хувьд судлахаас гадна байгаль, нийгэм, хүмүүнлэгийн бусад мэргэжлийн оюутнуудын хувьд энэ нь дэлхийн хөгжилтэй танилцах, даяаршлын талаар үндсэн ойлголтыг олж авч өөрийн мэргэжилтэй холбох, түүнээс ач холбогдлыг ойлгон таньж өөрт зөвөөр ашиглах зэрэг олон ач холбогдолтой хичээл болох нь оюутнуудын хариултаас харагдаж байна. Тиймээс оюутны энэхүү хэрэгцээ шаардлагад үндэслэн оюутнуудад дэлхийн үндсэн чиг хандлага даяаршлын эрин үед хэрхэн хувьсан өөрчлөгдөж буйг онол-практикийн харьцуулсан шинэ тутам тоо, баримтад үндэслэн уг хичээлийг үр өгөөжтэй байдлаар зааж оюутныг цаашид гүнзгийрүүлэн судлах суурийг тавих, оюутны сурах идэвхийг нь сэргээх, сэдэлжүүлэх явдал туйлын чухлаар тавигдаж байна.

Хэдийгээр уг хичээлийг 2019-2020 оны хоёрдугаар улиралд ОУХТ-ээс шинэчлэн баталсан хичээлийн хөтөлбөрөөр ОУХНУС-ийн олон улсын харилцааны тэнхмийн



4-5 багш энэ хичээлийн жилийн намрын улиралд, 3 багш хаврын улиралд тус тус зааж байгаа нь уг хичээлийг судалж буй бакалаврын түвшний нийт оюутнуудад ижил түвшний мэдлэг олгох зорилготой ч багш бүрийн уг хичээлийг зохион байгуулах арга барил, арга зүй, хичээлийн хүрээнд оюутанд эзэмшүүлэх чадвар, оюутны олж авсан мэдлэг, чадварыг дүгнэхээр өгөгдсөн даалгавар нь харилцан адилгүй байгаа юм.

1. Оюутны хөгжүүлсэн болон цаашид хөгжүүлвэл зохих чадварууд:

1.1. Хичээлийн жилийн туршид оюутанд гүйцэтгэхээр өгсөн даалгавар нь оюутны тодорхой мэдлэг, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн зорилтот үйл ажиллагаа байдаг. МУИС судалгаанд суурилсан их сургууль болно гэх зорилгын хүрээнд оюутнуудад өгч буй даалгаврын талаар нь оюутны судалгаа хийх чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн

7. МУИС-ийн тэргүүлэх чиглэл бол судалгаанд суурилсан сургууль болох явдал. Энэ хичээлийг зохион байгуулж буй арга барил дээрх тэргүүлэх чиглэлтэй нийцэж буй эсэх, таны бодлоор?

92 responses



10 responses

эсэх, таны бодлоор?


хичээлийн зохион байгуулж буй арга барил дээрх тэргүүлэх чиглэлтэй нийцэж буй МУИС-ийн тэргүүлэх чиглэл бол судалгаанд суурилсан сургууль болох явдал. Энэ

Тиймээс гэрийн даалгаврын хувьд оюутан тус бүрт дараах даалгавруудыг


гүйцэтгэхээр өгсөн. Үүнд:

1. Сард нэг удаа 1-3 хуудас бүхий 1 эссэ, нийт 3 эссэ бичих;
2. хичээлийн агуулгад багтсан сэдэв тус бүрээр 2-3 оюутныг нэг баг болгон хуваарилж хичээлийн агуулгаас сонирхол татсан нэг сэдвийг сонгон кейс-судалгаа хийж түүнийгээ илтгэх,
3. Мөн өөрсдийн кейс-судалгаанаас гарсан үр дүнгээ 5-10 хуудас бүхий судалгааны тайлан болгон бичих даалгаврыг өгсөн нь оюутны бүтээлч сэтгэн бодох, аналитик чадварыг хөгжүүлэх, асуудалд өөр өнцгөөс буюу шүүмжлэлт талаас хандах, бусдын санааг хуулбарлах бус өөрийн санаа, байр суурийг товч тодорхой илэрхийлж сурах, бусдын судалгааг хэрэглэсэн бол ишлэл зүүлт хийх, анхдагч болон хоёрдогч баримт бичгийн эх сурвалжийг ялган таних, гол нь хуучин, шинэ тоо баримтыг харьцуулж дүгнэлт хийх чадварыг хөгжүүлэх зорилгыг багшийн зүгээс тавьж ажилласан.
4. Судалгааны тайлан, эссэ бичих барил суулгах, анализ дүгнэлт хийхдээ хоёр төстэй зүйлийн ялгаатай талыг эсвэл хоёр өөр зүйлийн ижил төстэй талыг олж харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг чадварыг анхдагч түвшинд дадал болгож хэвшүүлэх зорилготой үйл ажиллагаа байв. Гарсан үр дүнг илрүүлэхийн тулд анги бүрээс илгээсэн оюутны судалгааны тайлангийн жишиг болгож 3-4 тайланд үндэслэн дүгнэлт хийлээ.

1.2. Хичээлийн хүрээнд олж авсан мэдлэг, чадвараа хэрхэн үнэлснийг дараах асуулгад хариулсан хариултаас дүгнэхэд: нийт оюутнуудын 50-60%-аас дээш нь онолын ерөнхий мэдлэг сайжирсан болон зарим судалгааны аргуудыг хэрэглэж сурсан 4-5 оноог өгсөн, нэгтгэн дүгнэх, харьцуулан шинжлэх чадвар сайжирсан гэж 70%-аас хүртэлх хувь нь, онолын мэдлэгийг практикт хэрэглэсэн, эссэ болон тайлан бичих чадвар мэдэгдэхүйц сайжирсан хэмээн 50% гаруй хувь нь тус тус хариулснаас үзэхэд оюутан бүрт тодорхой хэмжээний өөр өөр чадварыг шинээр суусан, чадвар нь өмнөхөөсөө мэдэгдэхүйц хөгжсөн гэж дүгнэхээр байна. Харин (5%) нь ямар нэгэн өөрчлөлт ажиглагдаагүй гэж хариулснаас үзэхэд өмнө нь бичих чадвар, аливаа асуудлыг харьцуулах, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэх дадлыг өөрт суулгасан эсвэл өмнөх шатны боловсролын байгууллагад туршилт судалгаа хийж байсан болох талтай.



6. Та энэ хичээлээр олж авсан өөрийн мэдлэг, чадварыг үнэлнэ үү? 1-5 оноогоор үнэлнэ үү? Хамгийн дээд оноо нь 5 байхаар тооцож хариулна үү?




2. Гэрийн даалгаврын гүйцэтгэл:

2.1. Энэ хичээлийг судлахаар сонгосон нийт оюутнуудад олон улсын харилцааны суурь ухагдахууныг онол-практик (case), практик (case)-онолын харилцан шүтэлцээн дээр тулгуурлан ойлгуулж, ингэснээр оюутнуудын цаашид гүнзгийрүүлэн судлах сонирхлыг өдөөж сэдэлжүүлэх нь миний хичээлийн гол зорилго байсан. Гэвч гэрийн даалгаврын гүйцэтгэлээс харахад намар, хаврын улирлын нийт оюутнуудын 15% хүртэлх хувь нь хоцрогдолтой өгсөн үзүүлэлтээс багш гэрийн даалгаврын гүйцэтгэхэд цаг хугацаа болон ачаалал хэтэрсэн байх магадлалтай гэж дүгнээд асуулгаар тодруулахад: асуулгад оролцогсдын 12.45% нь хүнд, 31.65% нь дунд зэрэг, 58.25% нь боломжийн, 3.4% нь хялбархан байсан гэж давхардсан байдлаар хариулжээ. Үүнээс харахад дийлэнх буюу 89.9% гаруй хувь нь дунд зэрэг, боломжийн гэсэн хариулт өгснөөс оюутнуудад семинар хичээлийн хүрээнд өгсөн даалгавар хэт их дарамт учруулаагүй байна гэж дүгнэхэд хүргэлээ.

Гэрийн даалгаврын талаар оюутны байр суурь

8. Энэ хичээлийн хүрээнд гэрийн даалгаврыг цаг хугацаанд гүйцэтгэхэд танд хэр байна вэ? Гэрийн даалгаврын ачааллыг та хэрхэн дүгнэж байна вэ?


92 responses



Гэрийн даалгаврын талаар оюутны байр суурь


8. Энэ хичээлийн хүрээнд гэрийн даалгаврыг цаг хугацаанд гүйцэтгэхэд танд хэр байна вэ? Гэрийн даалгаврын ачааллыг та хэрхэн дүгнэж байна вэ?

70 responses



2.2. Мөн судалгаанд суурилсан мэдлэг олгохын тулд оюутнуудад эссэ хэрхэн бичих, кейс-судалгаа хийхдээ юуг анхаарах, харьцуулалт хэрхэн хийх, судалгааны ямар аргуудыг хэрэглэж болох талаар багшийн зүгээс урьдчилсан зөвлөмж бичиж (Introduction of IR & Globalization 2020-2021 by B.D. facebook группт) байршуулсан нь судалгааны тайланг бичихэд дөхөм байсан тухай асуулгад өгсөн оюутнуудын хариултаас харж болно. Намрын улирлын оюутнуудад жишиг эссэ, судалгааны тайланг хавсаргалгүйгээр урьдчилсан зөвлөмжийг хүргэхэд оюутнууд ‘нөлөөлсөн’, ‘тодорхой хэмжээнд нөлөөлсөн’, ‘нөлөөлөөгүй’ гэх хариултауд ижил түвшинд байгаа бол хаврын улиралд жишиг эссэ, судалгааны тайлангийн хамт уг зөвлөмжийг хүргэхэд ‘сайн нөлөөлсөн’ гэх хариулт давамгайлсныг доорхи хүснэгтээс харж болно. Хаврын улирлын оюутнуудаас асуулгад оролцоходоо зөвлөгөөг уншиж, жишиг эссэ, тайланг судалсан ч ‘өөрөө хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна’ гэх хариулт өгснөөс дараагийн улиралд уг хичээлийг заахдаа эссэ болон судалгааны тайланг бичих бүтцийг сайн тайлбарлаж дадлага хийлгэх


ажилд тодорхой цаг гаргаж ажиллахыг багшийн зүгээс анхаарах болж байна. Харин ‘нөлөөлөөгүй’ гэсэн хариултыг өгсөн оюутнуудын хувьд өмнө нь тайлан эсвэл эссэ бичих дадлага хийж байсан туршлагыг өмнөх шатны боловсролын институци болон ерөнхий боловсролын сургуулиас олж авсан гэж дүгнэж байна.



2.3. Үүнээс гадна гэрийн даалгавар гүйцэтгэснээр өөрт хөгжүүлсэн чадваруудыг асуулгад оролцогсдоос тодруулахад намар, хаврын улиралд уг хичээлийг судалж буй нийт 162 оюутны 38% нь харьцуулах чадвар, 33.25% нь нэгтгэн дүгнэх чадвар, 30.15% нь задлан шинжлэх чадвар, 24.65% нь асуудлыг өөр өнцгөөс харж шүүн тунгаах чадвар тус тус сайжирсан хэмээн хариулснаас багшийн зүгээс өгч буй гэрийн даалгавар нь оюутны харьцуулж жиших, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадварыг тодорхой хэмжээнд хөгжүүлэхэд нөлөөлжээ. Харин хэр хэмжээний түвшинд хөгжсөнийг харьцуулан гаргахад хүндрэлтэй юм.

11. Гэрийн даалгаврын ажлыг гүйцэтгэснээр таны өөртөө шинээр хөгжүүлсэн чадварууд юу байв?

92 responses



11. Гэрийн даалгаврын ажлыг гүйцэтгэснээр таны өөртөө шинээр хөгжүүлсэн чадварууд юу байв?

70 responses



2.4. Асуулгын №9 асуултанд сар бүр 2-3 хуудас бүхий нэг эссэ нийт 3 эссэ, 2-3 оюутан нийлж багаар кейс судалгаа хийж үр дүнгээр нь PPP танилцуулах, үр дүнгээ тайлан бичих баталгаажуулах зэрэг гэрийн даалгаврыг гүйцэтгэхэд ямар хүндрэл гарсан талаар тодруулахад оюутнуудын дийлэнх нь ерөнхийдөө хүндрэл бага байсан гэхдээ дэлхий дахинд Ковид-19 цар тахлын нөхцөл байдал хүндэрснээс үүдэн хөдөө, орон нутагт байгаа оюутнуудын хувьд интернет, харилцаа холбооны хүрэлцээ муу, тог тасрах зэрэг техник технологийн шалтгаанаас үүдэн гэрийн даалгаврыг цагаас нь хоцруулах, багаар ажиллахад багийн бусад гишүүдтэй холбогдож чадахгүй байх, ар гэрийн гачигдал, номын санд суух боломжгүй тул сурах бичиг ашиглах боломжгүй, судалгаа хийхэд мэдээлэл олох эх сурвалж хомс, е-сурах бичгийн аксесс байхгүй, анх удаа тайлан бичиж байгаа тул туршлагагүй, гадаад хэлний мэдлэг муу, судалгаа хийхдээ монгол судлаачдын судалгааны хүртээмж муу тул гадаад хэлнээс орчуулах шаардлагатай болсноос цаг их алдсан, бүх хичээл дээр маш их даалгавар өгдөг, хувь хүний зохион байгуулалт муугаас цаг тулгаж даалгавраа хийдэг гэсэн нийтлэг хариултыг өгсөн байна. Зарим нэгэн хөл хорио, хувийн зохион байгуулалт зэрэг хүндрэл бэрхшээлүүд байгаа ч гэрийн даалгавруудыг хийх тусам оюутан хүний хувьд дараа дараагийн даалгавруудыг гүйцэтгэхэд хялбар санагдаж

буй нь хүндрэл гэж харахаас илүүтэйгээр маш олон чадварыг эзэмшиж байна хэмээн хариулжээ. Багшийн зүгээс оюутнуудын өгсөн хариултууд дээр үндэслэн 2021-2022 оны хичээлийн жилийн намрын улирлын эхний хичээл дээр эссэ бичих, кейс-судалгаа хэрхэн хийх зөвлөмжөөс гадна илүү практик үйл ажиллагаанд чиглэсэн тухайлбал: хуучин, шинэ тоон баримт дээр харьцуулалт хийхдээ өсөлт, бууралтыг ажиглаж шалтгааныг олж тогтоох, шалтгааныг улс төр, эдийн засаг, соёл, нийгэм, хувь хүнээс үзүүлэх нөлөөлөл гэх мэт ангилж болно зэрэг практик үйл ажиллагаанд суурилж хичээлээ заах арга зүйг баримтлан ажиллах аваас оюутнуудад хүндрэл багатайн дээр оюутны судалгаа хийх чадвар хөгжих боломжтой болохыг ойлголоо. (Доор намар, хаврын улирлын асуулганд оролцсон зарим оюутнуудын хариултаас хавсаргав. Зох.Д.Б.)

92 responses

Өмнө нь тэгж их эссэ тайлан бичиж байгаагүй туршлага муу нь надад хүндрэлтэй байсан гэхдээ миний бичих чадвар сайжирсан гэж бодож байна

Sudalгаа anh удаа hijj uzej bsn uchir oulgohgui hundreltei asuudal garsan

Huduu oron nutagt baigaa bolohoor data svjee orchin etc asuudluud tulgarch bna irehes omno shinjilgee hol horio bair ged bas asuudltai bailaa. Ternes bish hewiin daalgawrin system taalgdaj baigaaa

багийн гишүүнтэйгээц холбоо тогтооход хэцүү байсан

эссэ бичихдээ тааруу болхоор эссэний даалгавар хүнд санагддаг

huwiiin asuudal ar geriin baidal hundreltei baigaagaas gadna hul horio

Багийн хүүхдүүдийн идэвхигүй байдлаас гадна 1эсээ гэж бодож одоог хүрсэн нь миний буруу байсан тиймээс хоцроод оноогоо хасуулаад ч болов явуулна. Семинарын ахлагч буруу ойлгосноос болоод сэдвээ тулгаж авсан.

70 responses

Хүндрэлтэй байсан ч хийх л ёстой юм чинь. Гэхдээ бусад хичээлүүдтэй давхацсан. Мэдээж хувийн зохион байгуулалттай болж байгаа.

Миний хувьд багшийн өгсөн даалгаврыг хийхэд хүндрэлтэй зүйл байхгүй байсан ч ар гэрийн асуудлаар / эмээ нас барах/ хараахан идэвх муутай байна.

Эдгээр даалгавруудыг хийж гүйцэтгэхэд тийм ч их бэрхшээл гараагүй. Харин ч сар бүр эсээ бичсэнээр өөрийн сонирхсон нэг асуудлыг илүү сайн гүнзгийрүүлэн мэдэж дээрээс нь олон талаас харж дүгнэх чадварыг эзэвшиж байна. Багаараа хамтран илтгэл хийснээр судалгаа хийх чадварыг бага багаар эзэмшиж байна. Эдгээрээс харахад бэрхшээл гэхээсээ илүүтэй маш олон чадварыг эзэмшиж байна.

яг биеэр уулзаж хийхгүй болохоор багаар судалгаа хийхэд хэцүү санагдсан

hvdrel baihgь

Асуудал тулгараагүй. Харин хөл хорионы үед дүрд хувирах даалгавар хүнд байна. Хувцас хунараас авхуулаад төхөөрөмжийн асуудал тулгардаг.

2.5.Гэрийн даалгавар хэсгийн сүүлийн асуулгаар (№12) оюутнуудад цаашид хөгжүүлэх ямар чадварууд байгаа талаар тодруулахад оюутнуудын зүгээс дараах хариултыг өгсөн. Үүнд: эссэ чадвараа сайжруулах, эссэ бичихдээ баримт нотолгоонд суурилж бичих, анализ дүгнэлт хийж сурах, нэгтгэн дүгнэх, задлан шинжлэхэд чадвараа сайжруулах, асуудлыг олон талаас шүүн тунгаах чадвар, олон салангид зүйлээс нэг бүхэллэг дүгнэлт гаргаж сурах, мэтгэлцэх, илтгэх чадвараа хөгжүүлэх, багаар ажиллаж сурах, гадаад хэлний мэдлэгээ сайжруулах, ойлгомжтой тодорхой ярьж сурах, компьютерийн програмуудыг сайн ашиглаж сурах зэрэг олон чадваруудаа сайжруулах талын хариултуудыг өгчээ. Үүнээс дүгнэхэд оюутан бүр энэ хичээлийн хүрээнд эссэ бичих, кейс-судалгаа хийх, симуляци буюу дүрд-тоглох зэрэг даалгавруудын хүрээнд тодорхой чадваруудыг хөгжүүлсэн гэсэн хариултыг өгсөн ба цаашид ямар чадвараа хөгжүүлэхээ мэдэж авна гэдэг хамгийн чухал бөгөөд өөрийн сул тал юу байна, түүнийгээ хөгжүүлэхэд юу шаардлагатай вэ гэдгийг ухамсарлаж байна гэдэг нь оюутан хүний хувьд хүний хөгжил тал дээр ахиц гаргах нөхцөл бүрдэж байна гэж багшийн зүгээс дүгнэж байна. (Доор намар, хаврын улирлын асуулганд оролцсон зарим оюутнуудын хариултаас хавсаргав. Зох.Д.Б.)

92 responses

Haritsuulan zadlan shinjleh dugnelt gargah

Практик мэдээлэл дээр суурилсан мэдлэг эзэмших

Англи хэл сурах

Baihgui mash goy hicheel baisan bayrlalaa

Олон салангид зүйлээс нэг бүхэллэг дүгнэлт гаргах тал дээрээ ажиллаж байгаа.

Энэ хичээлийн хүрээнд судалгаа хийх тал дээр сайжирсан.

илтгэх, нягтруулж бичих

Бусадтай харилцах, баг хамт олноор ярилцах

Илтгэх ярих чадвар

70 responses

Sudalgaa hiih

цаг хугацаагүр бүтээлтэй өнгөрөөх

Юмны далд санааг сайн ухаж ойлгодог болох, хүлээцтэй хандах.

Судалгаагаа сайжруулах

Eseegee iluu bichdeg bolmoor baina

Бусдад санаагаа зөв тайлбарлах

hicheelin ehend англи hel deer sudalgaa zergiig geriin daalgavart unshij oilgohoor oguulsen mdeej ih surguulin oyutan англи heltei bh bn zuid niitsnldee ghde huuhed buriin 10 jilde sursan surguuli orchin oor,англи heleer buten sudalgaa oilgj unshih ni zarim ni hetsu bsn bh

Хичээлтэй холбоотой хөгжүүлж чадаагүй чадвар гайгүй гэж бодож байна.


3. Хичээлийн агуулгын талаарх оюутнуудын байр суурь:

3.1. Уг хичээлийн агуулга оюутнуудад хэр их ойлгомжтой байгаа, оюутны агуулгаас өөрт хэрэгцээт мэдээллийг олж авч байгаа эсэх, олж авсан мэдээллээ мэдлэг болгож боловсруулалтанд оруулж чадаж буй эсэхийг тодруулах нь асуулгын хамгийн сүүлийн чухал зорилт мөн. Хичээлийн агуулга ойлгомжтой, хүртээмжтэй байж гэмээ нь олон улсын харилцааны талаар ерөнхий, суурь ойлголтыг өгөх, оюутнуудын эрэлт хэрэгцээнд үндэслэн даяаршлын талаарх бүрэн ухагдахуун, дэлхий эргэн тойронд болж буй үйл явдлуудыг олон талаас харж анализ дүгнэлт хийх боломж бүрдэх юм. Асуулгад хариулсан байдлаас дүгнэхэд 77% нь хичээлийн агуулгын хувьд 80-100% дүнг, 23% хүртэлх хувь нь 60-80% хэмээн үзжээ. Үүнээс харахад салбар бүрээс уг хичээлийг ерөнхий эрдмийн суурь хичээлээр сонгон судалж буй оюутнуудын хувьд хичээлийн агуулга ойлгомжтой байсан гэж дүгнэж болохоор байна.

Хичээлийн агуулгын талаарх таны бодол?

13. Хичээлийн агуулга таны хувьд...


92 responses



Хичээлийн агуулгын талаарх таны бодол?

13. Хичээлийн агуулга таны хувьд...

70 responses




3.2. Оюутнуудын хичээлийн агуулгыг дэлгэрүүлж унших болон даалгавруудыг гүйцэтгэхдээ ямар эх сурвалж ашигладаг болохыг асуухад 162 оюутнаас:


1. ‘ОУХ-ны Үндэс ба Даяаршил’ зориулалтын сурах бичгийг 80-100%-тай ашигладаг нийт 21, 60-79% -тай гэсэн 29 хүн; 40-59% -тай гэсэн 28 хүн;

20-39%-тай гэсэн 20 хүн; 0-19%-тай гэж хариулсан 49 оюутан байна.

2. ‘НҮБ, ДХБ, ДЭМБ, Дэлхийн банк’ зэрэг ОУБ -ийн албан ёсны вебсайтыг 80-100%-тай ашигладаг гэсэн нийт 51 хүн; 60-79% -тай гэсэн 54 хүн; 40-59% -тай гэсэн 29 хүн; 20-39%-тай гэсэн 16 хүн; 0-19%-тай ашигладаг гэж хариулсан 12 оюутан байна.
3. ‘Гадаад хэл дээр бусад төрлийн сурах бичиг’-ийг хичээлд 80-100%-тай ашигладаг нийт 29; 60-79% -тай гэсэн 24 хүн; 40-59% -тай гэсэн 39 хүн; 20-39%-тай гэсэн 28 хүн; 0-19%-тай гэж хариулсан 42 оюутан байна.
4. ‘Diplomat, Foreign Policy’ зэрэг мэргэжлийн сэтгүүлийг 80-100%-тай ашигладаг нийт 26 хүн; 60-79% -тай 36 хүн; 40-59%-тай 32 хүн; 20-39%-тай гэсэн 27 хүн; 0-19%-тай ашигладаг гэсэн 40 орчим оюутан байсан.
5. ‘Google scholar, Google, Wikipedia’ зэрэг эх сурвалжийг 80-100% ашигладаг гэсэн нийт 112 хүн, 60-79% -тай ашигладаг гэсэн 30 орчим хүний хариултаас үзэхэд оюутан залуусын хувьд Ковид-19 цар тахлын үеийн нөхцөлд байдлаас улбаалан өөрт хамгийн ойр, боломжит эх сурвалжийг ашигладаг болох нь 112 хүний хариултаар хамгийн түрүүнд, ‘НҮБ, ДХБ, ДЭМБ, Дэлхийн банк’ зэрэг ОУБ -ийн албан ёсны вебсайтыг хэрэглэдэг гэх 51 хүний санал удаах байрыг эзэлж байна. ‘ОУХ-ны Үндэс ба Даяаршил’ хичээлд зориулсан сурах бичгийг 80-100%-тай хэрэглэдэг гэх оюутны тоо 21 буюу хамгийн бага байгаа нь хөл хорионы үед сурах бичгийн хүрэлцээ муу, материалын олдоц тааруу, хэвлэгдээд он хуучирсан, электронин хэлбэрт арай шилжиж амжаагүй зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалж болно. Гэсэн ч судалгаанд хэрэглэхэд найдваргүй эх сурвалжид тооцогддог хэдий ч хэрэглэхэд хялбар, хүртээмжтэйгээс нь шалтгаалан оюутнууд Google, Wikipedia зэргийг хамгийн их хэрэглэдэг нь ерөнхий суурь хичээлүүдийн гол гол сурах бичгүүдийг яаралтай электронон хэлбэрт шилжүүлэх онц шаардлага тавигдаж байна.

15. Та хичээлийн агуулгаа дэлгэрүүлж уншихдаа ямар эх сурвалжийг ашигладаг вэ?





3.3. Гадаад хэлний хувьд асуулгад оролцсон оюутнуудын 57.5% нь англи хэлийг, 39.4% нь монгол хэлийг, 1.4% хоёрдогч гадаад хэл буюу Орос, Франц, Герман хэлийг ашигласан бол 1.4% нь Хятад, Солонгос, Япон хэлийг хичээлээ гүнзгийрүүлэн судлахад хэрэглэдэг гэсэн үзүүлэлт гарчээ. Үүнээс үзэхэд англи хэлийг хэрэглэдэг 57.5% хувийн үзүүлэлтээс даяаршлын эрин үед оюутан залуусын гадаад хэлийг сонирхон судлах боломж, нөөц бололцоо ихтэй болсныг харж болох ч ‘уг хичээлийг англи хэл дээр судлах боломж олдвол судлах уу’ гэдэг асуулганд 162 оюутнаас ‘магадгүй’ хэмээн 78 (48.2%), ‘тийм’ гэж 45 (27.35%) хариулснаас үзэхэд англи хэлийг ойлгох чадвар нь оюутны хүссэн түвшинд эсвэл академик түвшинд хүрээгүй эсвэл уншиж ойлгох англи хэлний чадвар нь сонсож ойлгох чадвараас нь илүү байна хэмээж гэж дүгнэж болох юм.

16. Таны хичээлээ гүнзгийрүүлэн судлахдаа аль хэлийг түлхүү ашигладаг вэ?

92 responses



16. Таны хичээлээ гүнзгийрүүлэн судлахдаа аль хэлийг түлхүү ашигладаг вэ?


70 responses



‘Үгүй’ гэж хариулсан 37 (23%), ‘мэдэхгүй’ гэж хариулсан 17 (10%) оюутнуудын хувьд монгол хэл дээр хичээлээ судлах нь давуу гэж үзсэн бол судалгааг гүнзгийрүүлэн судлахдаа англи хэл дээрх материалыг судлах зайлшгүй шаардлагатай болж байна учир нь өмнөх “гэрийн даалгаврыг гүйцэтгэхэд оюутанд ямар хүндрэл бэрхшээл байна” гэдэг №9 дэх асуултанд монгол хэл дээр судалгааны хүртээмж муу хэмээн хариулснаас үзэхэд хичээлээ монгол хэл дээр судлаж болох ч англи хэлийг судалгаандаа зайлшгүй ашиглахаас өөр аргагүйд хүргэж байна.


18. Хэрэв уг хичээл англи хэл дээр заагддаг бол та сонгон судлах байсан уу?

92 responses




18. Хэрэв уг хичээл англи хэл дээр заагддаг бол та сонгон судлах байсан уу?

70 responses



3.4. Хичээлийг хөглөн явуулахдаа багш олон улсын харилцаанд өрнөж буй үйл явдлуудын талаарх оюутны онол, практик хосолсон мэдлэгийг баталгаажуулах үүднээс олон арга барил хэрэглэдэг. Тухайлбал богино хэмжээний видео 5-6, хичээлийн агуулгатай холбоотой кейс иш татаж ярих, гол судлаач хүний хэлсэн үгнээс иш татах, оюутнууд өөрсдөө семинар хичээлийн хүрээнд үгийн утга таалгах, үгийн сүлжээ бөглүүлэх зэрэг тоглоом тоглуулах, дүрд-тоглох буюу симуляци хийх, тоон судалгааг харьцуулсан график үзүүлэх зэрэг арга барилыг тогтмол хэрэглэдэг. Үүнээс аль нь хичээлийг ойлгоход илүү чухал вэ гэдэг асуултанд оюутнууд дараах

байдлаар хариулжээ. Үүнд:



- А. **Богино хэмжээний видео үзүүлэхэд** хичээлээ гүнзгийрүүлэн 80-100%-тай ойлгоход тусалдаг гэсэн 43 хүн; 60-79% -тай 49 хүн; 40-59%-тай 38 хүн; 20-39%-тай гэсэн 18 хүн; 0-19%-тай ойлгоход тусладаг хэмээн 13 хүн тус тус хариулжээ.
- Б. **Хичээлийн агуулгад холбогдох кейс** иш татаж ярихад хичээлээ гүнзгийрүүлэн 80-100%-тай ойлгоход илүү тусалдаг гэсэн 95 хүн; 60-79% -тай гэсэн 41 хүн; 40-59%-тай 18 хүн; 20-39%-тай ойлгоход тусалдаг гэсэн 7 хүн тус тус хариулжээ.
- В. **Үгийн утга тааилгах, үгийн сүлжээ бөглүүлэхэд** хичээлээ гүнзгийрүүлэн 80-100%-тай ойлгоход илүү тусалдаг гэсэн 47 хүн; 60-79% -тай гэсэн 43 хүн; 40-59%-тай 34 хүн; 20-39%-тай гэсэн 22 хүн; 0-19%-тай ойлгоход тусладаг гэсэн 16 хариулт тус тус иржээ.
- Г. **Судлаач хүний үгийг иш татахад** хичээлээ гүнзгийрүүлэн 80-100%-тай ойлгоход тусалдаг гэсэн 33 хүн; 60-79% -тай гэсэн 46 хүн; 40-59%-тай 43 хүн; 20-39%-тай ойлгоход тусалдаг гэсэн 26 хүн тус тус

хариулжээ.


Д. **Дүрд-тоглох буюу симуляци хийхэд** хичээлээ гүнзгийрүүлэн 80-100%-тай ойлгоход тусалдаг гэсэн 49 хүн; 60-79% -тай гэсэн 38 хүн; 40-59%-тай 18 хүн; 20-39%-тай ойлгоход тусалдаг гэсэн 18; 0-19%-тай ойлгоход тусладаг гэсэн хариултыг нийт 27 хүн тус тус ирүүлжээ.

Е. **Тоон судалгааг харьцуулсан график үзүүлэхэд** хичээлээ гүнзгийрүүлэн 80-100%-тай ойлгоход тусалдаг гэсэн 55 хүн; 60-79% -тай гэсэн 51 хүн; 40-59%-тай 29 хүн; 20-39%-тай 16 хүн; 0-19%-тай ойлгоход тусалдаг гэсэн 11 хүн тус тус хариулжээ. Дээрхи өгсөн хариултуудаас дүгнэхэд хичээлийн агуулгыг 80-100%-тай гүнзгийрүүлэн ойлгоход оюутнуудын хувьд ‘*кейс иш татаж ярихад*’ гэсэн хариулт 95 хүний буюу хамгийн өндөр саналыг, ‘*тоон судалгааг харьцуулсан график үзүүлэхэд*’ гэсэн 55 хүний хариултаар удаах саналыг авсан бол ‘*судлаач хүний үгийг иш татахад*’ гэдэг хариултаар хамгийн бага буюу 33 хүний саналыг авсан байна. Багшийн зүгээс дараа дараагийн улиралд уг хичээлийг заахдаа алдартай болон судлаач хүний үгнээс иш татах нь онолоос гадна судалгааг илүү үндэслэлтэй болгож батлах хүчин зүйл болдог гэдгийг практик хичээл дээр тусгайлан хэлж өгөх шаардлагатай болж байна.

3.5. “ОУХ-ны Үндэс ба Даяаршил” хичээлийг судалснаар аливаа асуудалд хандах хандлага өөрчлөгдөж, асуудлыг олон талаас шүүн тунгаах чадвар нэмэгдсэн гэдэг асуултын хүрээнд нийт судалгаанд оролцсон 162 оюутны 119 (73.4%) нь тийм гэсэн хариултыг, 47 (29%) нь магадгүй гэсэн хариултыг давхардсан байдлаар өгснөөс үзэхэд оюутнуудын олон улсын харилцаанд болсон, эсвэл өрнөж буй үйл явдлыг олон талын өнцгөөс харж шүүн тунгаах хэт нэг талыг барихгүйгээр эерэг сөрөг талаас нь эсвэл субъектуудын аль аль талаас нь объектив байдлаар тайлбарлах зэрэг дадал тодорхой хэмжээнд суусан гэдгийг хүлээн зөвшөөрсөн хариулт өгсөн нь сайшаалтай. Оюутны энэ чадварыг цаашид хөгжүүлэхдээ семинар хичээлийн мэтгэлцээний үеэр оролцож буй оюутан тус бүрээс лавшруулж асуух, тайлбарлах боломжийг олгосноор багш нь оюутны чадварыг хөгжүүлэхээс гадна оюутан бүртэй тулж ажиллах боломж бүрдэх юм.


19. Энэ хичээлийг судалснаар таны аливаа асуудалд хандах хандлага өөрчлөгдөж, асуудлыг олон талаас шүүн тунгаах чадвар нэмэгдсэн эсэх?

92 responses



19. Энэ хичээлийг судалснаар таны аливаа асуудалд хандах хандлага өөрчлөгдөж, асуудлыг олон талаас шүүн тунгаах чадвар нэмэгдсэн эсэх?

70 responses



ДҮГНЭЛТ

Миний бие уг хичээлийг 4 дөх жилдээ зааж буй бөгөөд 2020-2021 оны хичээлийн жилийн намар болон хаврын улиралд МУИС-ийн оюутнуудад ерөнхий эрдмийн суурь хичээлүүдийн нэг “ОУХ-ны Үндэс ба Даяаршил” хичээлийн хүрээнд 20 асуулт бүхий нэг ижил санал асуулгыг намрын улирлын 15 дах долоо хоногт, хаврын улирлын 12 дахь долоо хоногт тус тус боловсруулан авч түүндээ дүн шинжилгээ хийхийг зорьлоо. Уг асуулгад намрын улирлын 145-аас 92, хаврын улирлын 116-аас 70 оюутан, бүгд 162 буюу нийт оюутнуудын 60%-аас илүү хувь нь хамрагдлаа.

Уг судалгааны ажлын хүрээнд оюутнуудыг хэрхэн сэдэлжүүлэх буюу сурах сонирхлыг нь өдөөх зорилтыг тэргүүнд тавьж хичээлийн агуулгаа өмнөхөөсөө баяжуулж, семинар хичээлийг орчин үеийн оюутны хэрэгцээ шаардлагад үндэслэн чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн, мэдлэг бүтээх, оюутан төвтэй, интерактив хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөж, үүнээс гарсан үр дүндээ тулгуурласан цаашид оюутны мэдлэг чадваруудыг хөгжүүлэхэд чиглүүлж юуг анхаарч хэрхэн

оюутан тус бүртэй тулж ажиллах туршлагыг судалгааны үр дүнгээс олж авсан гэж хэлж болно.

Мэдлэг бүтээх үйл ажиллагааг боловсролын салбарт конструктивист онолын хүрээнд тайлбарлагдах бөгөөд мэдлэг динамик шинж чанартай тул байнгын хөдөлгөөнд оршиж хувь бүрийн өмнө нь олж авсан мэдлэг, туршлагад үндэслэн шинэчлэгдэн өөрчлөгдөж байдаг бөгөөд энэ үед шинэ мэдлэг үүсэх үйл явц аяндаа өрнөдөг гэж үздэг байна. Багш бол уламжлал заах арга зүйн хэв шинжид захиргаадах, удирдан чиглүүлэх үүрэгтэй байсан бол орчин цагийн конструктивист сургалтын аргаар оюутан мэдлэг бүтээх бүхий л нөөц бололцоо, боломжийг олгож байх гэдэг утгаараа зөвхөн чиглүүлэгчийн үүрэгтэй байна. Тиймээс оюутныг голдуу багаар ажиллуулах нөхцлийг бүрдүүлж бие биенээсээ харилцан суралцах, мэдэхгүй зүйлээ мэдэж авах, хөгжүүлээгүй чадвараа хөгжүүлэх ёстойг ухааруулан ойлгоход чиглүүлэхэд анхаарч ажиллана. Хичээлийн хөтөлбөр ч гол ерөнхий үзэл баримтлалаас задарч еөрнхийгөөс тусгай руу, бүхлээс жижиг нэгж хэсэг рүү шилжих байдлаар заагдана. Тухайлбал: олон улсын эдийн засгийн хөгжлийн загварууд гэдэг хичээлийн хүрээнд олон улсын харилцаанд манлайлагч, жанжлагч, нөлөө бүхий оролцогч улсуудын зарим нэг жишээ нь: АНУ, Япон, БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн загварыг авч үзээд цааш нь задлах оролдлогуудыг хийнэ. Япон, БНСУ-ын хөгжлийн загвар нь аль улсын загвартай ижил төстэй, юугаараа ялгаатай гэх мэт ангилахаас гадна ийм хөгжлийн загварыг бүтээхэд тухайн улсад улс төр, эдийн засаг, соёл, нийгэм талаасаа хэрхэн нөлөөлөв гэх мэтээр бүхлээс тусгай руу задрана гэсэн үг.

Судалгааны санал асуулга нь үндсэн гурван хэсгээс бүрдсэн бөгөөд нэгдүгээрт оюутны хөгжүүлсэн болон цаашид хөгжүүлвэл зохих чадварууд, хоёрдугаарт гэрийн даалгаврын гүйцэтгэл гуравдугаарт хичээлийн агуулгын талаарх оюутны байр суурь дэд хэсгүүдийн хүрээнд оюутнуудаас санал бодол, байр суурийг нь сонсож түүндээ үндэслэн дүгнэлт хийлээ. Нэгдүгээр зорилтын хүрээнд оюутнуудын өөрсдийн олж авсан мэдлэг, чадварыг дүгнэхэд: 50-60%-аас дээш нь онолын ерөнхий мэдлэг сайжирсан, зарим судалгааны аргуудыг хэрэглэж сурсан, нэгтгэн дүгнэх, харьцуулан шинжлэх чадвар сайжирсан гэж 70%-аас хүртэлх хувь нь, онолын мэдлэгийг практикт хэрэглэсэн, эссэ болон тайлан бичих чадвар мэдэгдэхүйц сайжирсан хэмээн 50% гаруй хувь нь тус тус хариулснаас үзэхэд оюутан бүрт тодорхой хэмжээний өөр өөр чадварыг шинээр суусан, чадвар нь өмнөхөөсөө мэдэгдэхүйц хөгжсөн гэж дүгнэхээр байна. Хоёрдугаар зорилтын хүрээнд гэрийн даалгаврын гүйцэтгэлээс нийт асуулгад оролцогсдын 12.45% нь хүнд, 31.65% нь дунд зэрэг, 58.25% нь боломжийн, 3.4% нь хялбархан байсан гэж давхардсан байдлаар хариулжээ. Үүнээс харахад дийлэнх буюу 89.9% гаруй хувь нь дунд зэрэг, боломжийн гэсэн хариулт өгснөөс оюутнуудад семинар хичээлийн хүрээнд өгсөн даалгавар хэт их дарамт учруулаагүй байна гэж дүгнэлээ. Гуравдугаар зорилтын хүрээнд хичээлийг хөтлөн явуулахдаа багш олон улсын харилцаанд өрнөж буй үйл явдлуудын талаарх оюутны онол, практик хосолсон

мэдлэгийг баталгаажуулах үүднээс олон арга барил хэрэглэдэг. Тухайлбал богино хэмжээний видео 5-6, хичээлийн агуулгатай холбоотой кейс иш татаж ярих, гол судлаач хүний хэлсэн үгнээс иш татах, оюутнууд өөрсдөө семинар хичээлийн хүрээнд үгийн утга таалгах, үгийн сүлжээ бөглүүлэх зэрэг тоглоом тоглуулах, дүрд-тоглох буюу симуляци хийх, тоон судалгааг харьцуулсан график үзүүлэх зэрэг арга барилыг тогтмол хэрэглэж ирсэн. Хичээлийн агуулгын талаарх оюутны байр суурийг харахад нийт оюутнуудын 77% нь хичээлийн агуулгын хувьд 80-100% дүнг, 23% хүртэлх хувь нь 60-80% хэмээн үзжээ. Үүнээс харахад салбар бүрээс уг хичээлийг ерөнхий эрдмийн суурь хичээлээр сонгон судалж буй оюутнуудын хувьд хичээлийн агуулга ойлгомжтой байсан гэж үзлээ.

Түүнчлэн “ОУХ-ны Үндэс ба Даяаршил” хичээлийг судалснаар аливаа асуудалд хандах хандлага өөрчлөгдөж, асуудлыг олон талаас шүүн тунгаах чадвар нэмэгдсэн үү гэдэг асуултын хүрээнд нийт судалгаанд оролцсон 162 оюутны 119 (73.4%) нь тийм гэсэн хариултыг, 47 (29%) нь магадгүй гэсэн хариултыг давхардсан байдлаар өгснөөс үзэхэд оюутнуудын олон улсын харилцаанд болсон, эсвэл өрнөж буй үйл явдлыг олон талын өнцгөөс харж шүүн тунгаах хэт нэг талыг барихгүйгээр эерэг сөрөг талаас нь эсвэл субъектуудын аль аль талаас нь объектив байдлаар тайлбарлах зэрэг дадал тодорхой хэмжээнд суусан гэдгийг оюутнууд хүлээн зөвшөөрсөн байна. Мөн уг хичээлийг англи хэлээр хөтлөн явуулах хөтөлбөрийг манай тэнхмийн зүгээс боловсруулж бэлтгэл ажил хангагдаж байгаа ч англи хэлээр лекцээ сонсож, харилцан чөлөөтэй ярилцах, академик судалгаа хийх чадвар нэгдүгээр дамжааны оюутнуудын хэдэн хувьд нь байгаа эсэхийг харгалзаж үзэх нь зүйтэй мэт санагдана. Санал асуулгын үр дүнгээс харахад 162-аас 45 оюутан л англи хэлээр судлахад бэлэн гэдэг хариулт өгснөөс харахад МУИС-ийн оюутнуудын англи хэлний түвшинг шат ахиулах нь сургалтын чанарыг сайжруулахад чухал хэмээн дүгнэлээ.

Эцэст нь “Танд хичээлтэй холбогдуулж хэлэх санал байна уу” гэсэн асуулгын хамгийн сүүлийн асуултанд дараах байдлаар хариулжээ. Сурах зорилгод нийцэж буй цөөхөн хичээлүүдийн нэг, оюутны мэдлэг, чадавхыг хөгжүүлэхэд анхаарч нь сайшаалтай, өргөн хүрээний мэдлэгийг маань тэлэхэд нөлөөлж байгаа, агуулга нь хоорондоо их уялдсан, онол-практикийг холбож чадсан, статистик мэдээлэл сүүлийн үеийнх байдаг нь таалагдсан, судалгаа хийхдээ гадаад эх сурвалжийг боловсруулж сурсан гэх мэт хариулснаас гадна багшийн зүгээс анхаарах зарим нэг саналуудыг ч оюутнаасаа нэргүй асуулгаар олж авлаа. Үүнд: PPP бэлдэхдээ нэг нүүрэн дээр хэтэрхий олон үг бичихгүй байх, зарим тодорхойлолт, тайлбарууд англи хэл дээр байдаг тул ойлгоход хэцүү байдаг, хөл хорионы үед оюутнуудыг теамзээр бүртгэхгүй байвал зүгээр, симуляци буюу дүрд орох хичээлд хамрагдаж чадахгүй байгаа нь тухайн оюутны микрофон, камер байхгүйгээс шалтгаалж байгаа ч өөр даалгавраар бас орлуулж болох юм, семинар хичээл дээр цаг гарвал өөр олон кейс дээр ангийн хүүхдүүдтэйгээ ярьж, шийдэл, гаргалгааг хамтдаа олж байвал бүүр зүгээр, англи хэл дээр бэлтгээд монголоор тайлбарлаж явуулвал

зүгээр зэрэг олон саналуудыг оюутнуудаас хүлээн авлаа. Багшийн зүгээс эдгээр саналыг хүлээн авч цаашдын сургалтандаа анхаарч ажиллах болно.

НОМ ЗҮЙ

Намрын улиралд 92 оюутнаас авсан санал асуулгын үр дүн
Хаврын улиралд 70 оюутнаас авсан санал асуулгын үр дүн

Англи эх сурвалж:

<http://www.buffalo.edu/ubcei/enhance/learning/constructivism.html>

Жишиг тайлан №1.

Монгол дахь “Эмнести Интернэшнл”-н үйл ажиллагаа²

Үндэслэл

“Эмнести Интернэшнл” нь 150 гаруй орны 7 тэрбум дэмжигчидтэй хүний эрхийн төлөөх үйл ажиллагаа явуулдаг хараат бус бие даасан байгууллага юм. Монгол дахь “Эмнести Интернэшнл” нь нийт 25 бүлэг 6000 гаруй гишүүд дэмжигчидтэй 20 гаруй жил үйл ажиллагаа явуулж байна.

Монголд олон улсын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, хүртээмж нь оновчтой эсэх, зорилтот иргэдэд хүрч ажиллаж байгаа эсэх тал дээр оюутнуудын хүрээнд болон “Эмнести Интернэшнл” дээр хийсэн судалгааны үр дүн.

Ашигласан судалгааны аргууд

- Ярилцлага
- Ажиглалт
- Асуулга
- Мэдээлэл цуглуулалт

Зорилго

Энэхүү судалгааны зорилго нь олон улсын сайн дурын байгууллагууд (Эмнести Интернэшнл) Монгод улсад үзүүлж буй үр нөлөө, үүрэг оролцоог судлахад оршино.

Таамаглал

- Засгийн газрын агентлагуудтай хамтарч ажилладаг
- Бүх “Эмнести Интернэшнл”-ийн салбаруудтай ижил үйл ажиллагаа явуулдаг
- Том байгууллага учраас ивээн тэтгэгч байгууллагуудын дэмжлэг их

Асуулт

1. Нийт хэдэн гишүүнтэй вэ?
 - Залуучуудийн бүртгэл 4590 (25 наснаас доош)
(Идэвхитэй гишүүд 40,50) Гишүүнчлэлийг хасдаггүй.
2. Зохион байгуулсан үйл ажиллагааныхаа үр дүнгээс дурдвал?
 - Монголд зөвхөн “Эмнести Интернэшнл” үйл ажиллагаа явуулдаг. Түр орон сууцанд орсон, гэрээнүүд шинчлэгдсэн, эрх нь зөрчигдсөн 27 бүлэг байгуулагдсан, БЗД-д сүүлд байгуулагдсан, Хонг-Конгын шүүхэд хандсан, Засгын газар, Азийн хөгжилтэй банк хариуцлага тооцсон. Орон байртай байх эрх зүйн хөтөч, Нээлттэй нийгэм форум (компанит ажилын зохицуулагч) хуульчидтай хамтран стратегийн бүлгэмтэй болсон.
3. Хамтран ажиллагч байгууллагуудын талаар?
 - Байгууллагын үнэт зүйлтэй таарч байвал хамтарч болно. Дотоодын төрийн бус байгууллагуудыг чадваржуулдаг (гинжийг тасля-анх 2012 онд Эмнести интернэшнл зохиож байсан) хүний эрхийн форумын гишүүн байдаг. ОУБ “Эмнести Интернэшнл”-аас бусад нь үндэсний төрийн бус байгууллагууд. Хуулийн зөвлөх бас байж болно.
4. Хэдэн цагийн сайн дурын ажил хийх шаардлагатай вэ?
 - 2 жилийн идэвхитэй ажил. Гэрээ хийж 100цаг ажиллан батламж авч болно. Сайн дурын ажилтны гэрээ байдаг.
5. Эрх нь зөрчигдсөн хүмүүсээ хаанаас яаж олдог вэ?
 - Өргөдлөө бариад өөрсдөө ирдэг. Хүний эрхийн үндэсний комис-р шийдүүлж чадаагүй асуудлаа манай байгууллагаар дамжуулж шийдүүлдэг.
6. Засгийн газартай адилхан үйл ажиллагаа явуулдаг уу?
 - Үгүй ээ. Хүмүүнлэгийн байгууллага биш. Улс улсын Эмнести өөр өөр үйл ажиллагаа явуулдаг. Одоогийн байдлаар Монголын Эмнести хорт бодис хадгалалт, хамгаалалтаар үйл ажиллагаа явуулж байна. Манлайлж ажиллах сэдвүүд дээр л анхаарч ажилладаг.
7. Одоогоор гаргаад буй хамгийн том үр дүн?
 - Монголд байгуулагдснаасаа хойш бн жилийн дараа эрүүдэн шүүх асуудлаар хуульдаа өөрчлөлт оруулсан. 14н хүний эрхэд ээлтэй сургуульд сургалт зохион байгуулсан. Эрхээ мэдье илтгэх урлаг

² МУИС, Хэрэглээний ШУС оюутан О.Цэнгүүн, ШУС-ийн оюутан Б.Мөнхзаяа, н.Содгэрэл

мэтгэлцээний тэмцээнийг 10дахь жилдээ зохион байгуулав. Хуулийн төслүүд дээр ажилладаг, Эмнести төслийн нэмэлт санаа оруулдаг. Хүний эрхийн хичээл их дээд сургуульд ордог болсон.

8. Ирээдүйн үйл ажиллагааны зорилго чиглэл?
 - Эмнести интэрншл-ийн дэлхий нийтийн стратеги төлөвлөгөө өөрчлөгдөж байгаа. Үзэл бодлоо тайван жагсаал цуглаан хийж илэрхийлэх, жендэрт суурилсан хүчирхийлэл.
9. Өөрсдөө бие даан судалгаа хийдэг үү?
 - Тийм. Өвөр Монголтой хамтран судалгаа хийсэн.
10. Тайлангаа жилд хэдэн удаа гаргадаг вэ?
 - Улирал тутамдаа тайлант үр дүнгээ явуулдаг.
11. Үр дүнгээ юугаар хэмждэг вэ?
 - Байгууллагын нууц

ДҮГНЭЛТ

1. Үйл ажиллагааны хувьд томоохон олон улсын байгууллагууд нь тухайн улс орнуудаасаа шалтгаалан өөр өөр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд гагцхүү зөвхөн том байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ нь янз бүр байдаг. Тухайлбал бидний таамаглалаар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хэдий ч тухайн улсад явуулж буй үйл ажиллагаа нь оновчтой бус байдаг.
2. Тусламж хэрэгтэй байгаа хүмүүстэй хэрхэн холбогдох арга зам нь нэгдсэн тогтолцоотой бус харин тухайн иргэд өөрсдөө уг байгууллага дээр очин эрх нь зөрчигдсөн талаарх гомдол өргөдлөө өгдөг байна.
3. Гишүүнчлэлийн хувьд Монгол улсын хувьд төрийн бус байгууллагуудад бүртгэлтэй гишүүд сайн дурын ажил гэхээс илүүтэйгээр гишүүн гэх нэр, баталгааны төлөө өөрийн эрх ашигт зориулан гишүүн болон бүртгүүлж үйл ажиллагаануудад оролцох идэвх харьцангуй сул байсаар байна.
4. Ивээн тэтгэгчдийн хувьд олон улсын томоохон төрийн бус байгууллага болох “Эмнести Интернэшнл”-ийн хувьд хэдий цар хүрээ том, олон чухал үйл ажиллагаа явуулдаг хэдий ч бусад байгууллагуудын дэмжлэг ивээн тэтгэгчдийн хувьд өөрсдийн ашгийг түрүүнд тавьж ивээн тэтгэхээс татгалзаж байсан байгууллагуудтай таарч байсан удаатай. Зарим албан байгууллага, хувь хүмүүс өөрсдийн эрх үүргийг ухамсарлан хувь нэмэр, хандив тусламж өгөх нь байдаг ч том байгууллагууд хүний эрхийн төлөө ажиллаж буй төрийн бус байгууллагуудыг дэмжихээс татгалзаж байгаа нь харамсалтай.

Жишиг тайлан №2

Судалгааны тайлан сэдэв: “Цаазын ялыг хориглох нь зөв”³

Агуулга

Энэхүү сэдвийн хүрээнд “Цаазын ял олгох нь зөв, буруу” гэсэн дэлхий нийтийн маргаантай асуудлыг хөндөж, цаазын ял хэрхэн хүний суурь эрхийг үгүйсгэж, цаазын ял олгоход арьс өнгө, газарзүйн байршилаас хамаарч хэрхэн ялгаатай оногддог, цаазаар авах ял нь хорих ялаас зардал болон эрсдэл өндөртэй болох, гэмгүй хүн хэрхэн хэлмэгдэх боломжтой зэргийг судалж статистик, баримт ашиглан санаагаа нотолж бичив.

Оршил хэсэг

Хүн амын дундах гэмт хэрэгтний амыг хороох нь гэмт хэргийг бууруулах хамгийн зөв арга гэсэн түгээмэл үзэл, хандлагатай холбоотойгоор хүний эрхийг дээдэлсэн, үйлдсэн хэрэгтэнг зөв олж тогтоох, хүн бүрт ижил, хэрэгт нь тохирох хариуцлага хүлээлгэх, бага зардлаар засан хүмүүжүүлэх, хамгийн чухал нь хүнд ноцтой гэмт хэргийг таслан зогсоохын тулд цаазын ялыг хориглох нь зөв гэсэн үзэл баримтлалыг нотолгоо, судалгаагаар батлан бичэв.

Сэдвийн судлагдсан байдал

Уг сэдэв нь дэлхийн нийтийн анхаарлыг татсан асуудал тул олон талын судалгаа шинжилгээ түгээмэл хийгдсэнээс найдвартай эх сурвалж болох:

1. Цаазын ял талаарх мэдээллийн төв⁴ түүний салбар төвүүдийн хийсэн судалгааг ашиглав.

Судалгааны арга, аргачлал

Тоон ба чанарын судалгааны аргийг хослуулан ашигласан бөгөөд судалгаандаа ашиглаж анализ дүгнэлтийг хийсэн.

Үр дүн 1 ийн дэмжигч баримтын эх сурвалж⁵

Үр дүн 2 – 2018.10.18. Өдрийн сонин МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.Мөнхсайхантай ярилцсан нийлэл⁶

Үр дүн 3⁷

АНУ-д гэм буруугүй хүмүүс хоригдсон тоо, судалгаа⁸

Судалгааны үр дүн

Судалгааг хийснээр гэмт хэрэг үйлдсэн гэж тодорхойлогдтол тухайн хүн энгийн иргэн, хорих ялаар шийтгэгдэсний дараа буруугүй байсан нь гэрчлэгдэх тохиолдол байдаг, хуулийн шийдвэр гэрчийн мэдүүлэгээс хамаардаг тул гэрч дарамт, сүрдүүлэгээс хамааран худал мэдээлэл өгөх боломжтой, өмгөөллийн үйлчилгээг өөрсдөө төлөн авдаг тул ядуус хэрэгт тохогдох хандлагатай байдаг зэргээс хамаарч хүчирхийлэл, аллага, хүнд ноцтой гэмт хэргийн шийдэл нь цаазын ял байх хэрэггүй бөгөөд үр дүнгүй гэж дүгнэв.

1. Цаазын ял хүн бүрт адилхан оноогддоггүй

АНУ бол одоог хүртэл цаазын ял үйлдэж буй томоохон улсуудын нэг юм. Вашингтон мужид төсөөтэй хэргийн тохиолдолд цагаан арьстай гэмт хэрэгтэнтэй харьцуулахад өнгөт арьстай гэмт хэрэгтэнд цаазын ял олгох тохиолдол 3 дахин илүү байдаг. (Prof. K. Beckett, Univ. of Washington, 2014) Луизиана мужид хэргийн хохирогч нь цагаан арьстан бол хар арьстан хохирогчийн хэрэгтэй харьцуулахад цаазын ял олгох хувь 97% илүү байдаг. (Pierce & Radelet, Louisiana Law Review, 2011) гэх мэт судалгаанаас дүгнэвэл “Хүн бүр эрхийнхээ хувьд адил тэгш” гэсэн хүний эрхийн түгээмэл тунхаглал зөрчигдөж хар арьстан хохирогчоос цагаан арьстан хохирогч илүү үнэ цэнэтэй гэж үзсэн, адил хэргийн тохиолдолд ч цагаан арьст гэмт хэрэгтэнээс хар арьст гэмт хэрэгтэн илүү хэрцгий, аймшигтай гэж тогтоогдон цаазын ял авах тохиолдол гарч байна. Энэ судалгаа тоо баримт бол адил гэмт хэрэг үйлдсэн байсан ч харагдах байдал, арьс өнгөөсөө хамаарч ялгаатай дүгнэгдэж байгаагийн томоохон илрэл юм.

Монгол улсад өмгөөллийн үйлчилгээ авахад өмгөөлөгчөөр ажилласан жил, туршлага, мэргэшсэн чиглэлээс хамаарч үйлчилгээний хөлс нь ихэсдэг. Эдийн засгийн боломжтой бол хэдэн ч хуульч авах эрхтэй бөгөөд

³ МУИС, ОУХНУС-ийн нэгдүгээр түвшний оюутан Г.Мөнхболор.

⁴ <https://deathpenaltyinfo.org/>

⁵ https://files.deathpenaltyinfo.org/documents/pdf/FactSheet.f1605882308.pdf?fbclid=IwAR1-GRroDqBWrsb-5FQYTEmy0xw-_YgyxITWsTdDpmCymE-cWxGQtUHCoxQ

<https://www.legalinfo.mn/law/details/9289>

⁶ <https://dnn.mn/>

⁷ <https://law.jrank.org/pages/12004/Causes-Crime.html>

⁸ https://www.brennancenter.org/sites/default/files/publications/Unnecessarily_Incarcerated.pdf

төлдбөрийн чадваргүй яллагчидад “улсын өмгөөлөгч” (Монгол улсын хууль) олгогддог бөгөөд шууд оноох зарчмаар явагддаг тул ашиг сонирхолын зөрчил гэх мэт асуудлаас улбаалан иргэдийн дунд улсын өмгөөлөгчидөд итгэх итгэл бага, харин хувийн өмгөөлөгч авах шаардлагатай гэсэн хандлага бодит амьдрал дээр түгээмэл харагддаг. Хувийн өмгөөллийн байгууллагийн зөвлөгөө зарим нь үнэ төлбөргүй байхад олон жилийн туршлагатай газрууд 20,000-аас эхэлж хэргийн төрлөөс өмгөөллийн хөлс хамаарна гэх үндэслэлээр үйлчилгээний хөлсийг олон нийтэд ил болгодоггүй байна.

Дээрх дурдсан нөхцөлүүд дээр үндэслэн тухайн хүний хэргийн түвшнээс үл хамааран арьс өнгө, нийгэмд эзлэх байр суурь, эдийн засгийн чадавх зэрэг нь шийдвэр гаргалтанд нөлөөлдөг гэж үзэж байна. Ижил төстэй хэрэг үйлдсэн байтал, нэг хүн нь амь насаа эцэслүүлэн, нөгөөх нь ухаажих боломж өгнө гэдэг нь туйлын шударга бус байдал бөгөөд хэрэв цаазын ялыг хэрэгжүүлвэл хүн бүрт тохирсон шийтгэлийг эрх тэгш, шударгаар олгож чадах уу? гэдэг нь эргэлзээтэй асуудал. Монгол улсын болон олон улсын түвшинд 100% хөдлөшгүй баримтаар хэргийг тогтоож чаддаггүй бөгөөд олдсон нотлох баримт, 2 талын өмгөөлөгчийн чадвар, гэрчийн мэдүүлгээс хамааран дүгнэлтэнд хүрдэг тул эдийн засгийн чадамжгүй бүлэг хэрэг үүрэх, буруутгагдах магадлал өндөр. Үүнээс хамаарч, гэмт хэрэг буурах биш улам далд явагдах, мөнгөний чухал хэрэгцээтэй байгаа хүмүүсээр үйлдүүлэх, гэрчид авилга өгч худал мэдүүлэг өгүүлэх гэх мэт нөхцөлүүд түгээмэл гарах хандлага нэмэгдэнэ.

2. Цаазаар авах бол хэлмэгдүүллтийн хамгийн том зэвсэг ба нотолгоо эргэх үе

Зөв хүн зөв шийтгэлээ хүлээх эрхтэй. Гэвч эрүү шүүлтийн явцад өнөөдөр буруу гэж тогтоогдсон боловч маргааш нь зөв байсан гэсэн нотолгоо гарж ирж болно. Монгол улсын хувьд ихэнх тохиолдолд хөдлөшгүй, баттай нотолгоогоор гэм бурууг тогтоож чаддаггүй бөгөөд гэрчийн мэдүүлэг хэрэг шийдвэрлэлтэнд чухал нөлөөтэй. Хэрэв алдаатай шийдвэрийн дагуу хэн нэгэн цаазын ял оноож, нас барсаны дараа нь гэм буруугүй байсан нь батлагдвал яах вэ, амыг нь хэнээс нэхэх вэ гэдэг асуудал гарж ирнэ. 2000 оны Монгол Улсад цаазаар авах ялыг оногдуулсан шүүхийн шийдвэрт анализ хийсэн судалгааны дүгнэлтээр нийт цаазаар авах ялд оногдуулсан шүүхийн шийдвэрийн 30 хүртэл хувь алдаа гаргах магадлалтай гэж гарсан. Гэм буруугүй хүнийг цаазлах магадлал 30 хувьтай байгаа хэрэг. (О.Мөнхсайхан)

1958-2011 он хүртэл манай улсад 870 хүнд цаазаар авах ял оногдуулсан бөгөөд энэ мэдээлэл төрийн нууц тул ямар хүн, ямар хэргээр цаазлагдсан нь нийтэд ил биш, тэр хэмжээгээрээ буруу хүн, эсвэл бүр хоосон хэрэгт ч хүнийг татан шийгээх буюу огт гэм буруугүй хүний амьд явах эрхэнд нь халдсан байх боломжтой нөхцөл байдал ажиглагдаж байна. Үүний тухайд “цаазаар авах ял оногдуулах ажиллагаанд өмгөөлөгч, шүүгч, прокурорын хувиар оролдож байсан хүмүүс гэм буруугүй хүнийг цаазалсан байх үндэслэлтэй гэж харамсаж явдгаа надтай хуваалцаж байсан” (хууль зүйн доктор О.Мөнхсайхан)

АНУ-д 1973 оноос хойш цаазын ял хэрэгжүүлж байгаа бөгөөд 170 гаруй хүн шүүхийн буруу шийдвэрээс хамааран хийгээгүй хэрэгийнхээ төлөө цаазын ял хүртсэн байна. (Innocence, DPIC)

Хэргийн үйлдэгчийг зөв тодорхойлоогүй, хэрэг байхгүй байхад ч гэм буруугүй хүн хэлмэгдэж хариуцлага хүлээх, гэмт хэрэг үйлдээгүй хүн гэмт хэрэгтэн гэж буруу тогтоогдон тухайн хүний амыг хорооно гэдэг нь эцэст нь цогцосоос уучлалт гуйх нөхцөл байдалд хүргэнэ. Үүргээ биелүүлж эрхээ эдэлж явсан хүнийг буруу шийдвэрийн үр дүнд суурь эрх буюу амьд явах эрхийг нь хассан гэсэн үг. “Цаазын ял гэм буруугүй нь хожим тогтоогдох үед цагаатгагдах боломжийг үгүй хийдэг учир би эсэргүүцдэг” (хүний эрхийн хамгаалагч Ц.Оюунгэрэл)

3. Цаазын ял гэмт хэргийн гаралтыг бууруулдаггүй.

Монгол улсад цаазаар авах ялыг хэрэглэж байсан 2002-2009 оны үед хүнийг санаатайгаар алах гэмт хэргийн тоо жилд дунджаар 294 гардаг байжээ. Цаазаар авах ялыг халснаас хойш буюу 2010-2017 оны хооронд жилд 213 болж буурчээ. Эндээс харвал хүний хэрэг үйлдэх явц нь цаазын ял хэрэгждэг эсвэл үгүйтэй холбоогүй.

АНУ-д хийсэн судалгааг дүгнэвэл хүн гэмт хэрэг үйлдэхдээ цаазаар авах ял байна уу үгүй юу гэдгийг боддоггүй. Хүчирхийлэл үйлдэгчдийн /бэлгийн хүчирхийлэл, аллага, хүнд хэлбэрийн дээрэм/ 30-50% нь архи, мансууруулах бодис давтамжтай хэрэглэдэг хүмүүсээр үйлдэгдсэн бөгөөд гэмт хэрэг нь гэрэлтүүлэггүй, хотын зах орчимд хийгдсэн байдаг байна. АНУ-ын шоронд хоригдож буй хүнд гэмт хэрэгтэнүүдийн 79% нь хар тамхины донтотл эсвэл сэтгэцийн өвчинөөс ангижрах эмчилгээ авч байгаа бол 40% нь сэтгэцийн өвчтэй, хар тамхинаас бүрэн хамааралтай хүмүүс байна. (хэрэгцээгүй хоригдогчид, судалгааны ажил) Үүнээс харвал, гэмт хэрэгтэнүүд 100% өөрийгөө хянах чадваргүй, мансууруулах бодисоос бүрэн хамааралтай, сэтгэцийн эмгэг өвчтэй байдаг. Иймээс хүнд гэмт хэргийг хийсний дараа нь шийдвэрлэхээс илүү хэрэг гаргахгүй байх нөхцөлийг бүрдүүлж архи, мансууруулах бодисонд донтгогчид хар аа хяналтандаа байлгаж, ангижуулах арга хэмжээг авч, сэдээх хүчин зүйлс болох хүчирхийлэл үйлдэх боломж бүрдсэн орчинд гэрэлтүүлэг, зам, хамгаалалтын системээр шийдэж өгөх нь хүчирхийллийг зогсоох илүү дээр шийдэл юм. Шоронд хоригдогч хүмүүсийн асуудлыг мэддэг хэрнээ хорихоос өөр хариу арга хэмжээ авдаггүй. Архинд донтсон хүмүүст цуврал хичээл ордог, харин сэтгэцийн эмгэгтэй хоригдогчид ямар ч хариу арга хэмжээ авдаггүй. Эрхийг нь хязгаарладаг, харин засрах боломж олгодоггүй. Тийм ч учраас The New Mental Hospitals буюу сэтгэцийн эмгэгтэй хүмүүст зориулсан зөвлөгөө, эмчилгээний эмнэлэг байгуулагдсан байна. 25-аас доош насныхан сэтгэл зүйн хувьд бүрэн боловсроогүй гэж

дүгнэдэг бол одоогийн хүнд гэмт хэрэгтэний 10% болох 50-аас дээш насныхан шоронгоос гарсанаас хойш ахин гэмт хэрэг үйлддэггүй гэсэн судалгаа байна. (гэмт хэрэгтийн шалтгаан, АНУ) Эндээс харвал, хүчирхийлэгчид, хүнд ноцтой гэмт хэрэгтэнүүдийг засан хүмүүжүүлэх нь боломжтой, биелэгдэхүйц ажил юм.

ДҮГНЭЛТ

Бага насны хүүхэд хүчирхийлнэ, төлөвлөгөөтэйгөөр хүний амь насанд хүрнэ гэдэг нь мэдээж аймшигтай үйлдэл. Бидний зорилго бол энэ мэт хүчирхийллийг зогсоох. Гэвч тухайн иргэний гэмт буруутай нь бүрэн тогтоогдох хүртэл тухайн хүн сэжигтэн, энгийн иргэн. Ял эдлэх хугацаанд гэм буруугүй нь тогтоогдох үндэслэл гарвал тухайн иргэн буцан нийгмийн амьдралд хэвийн оролцох эрхтэй. Харин цаазын ял ялгаварлан гадуурхалттай, энгийн иргэний амыг егүүтгэх өндөр магадлалтай, эрсдэлтэй гаралгаа юм. Хэргийг хийсэн хэрэгтэнд нь үрүүлж, юу хийснийг нь сануулж, түүнийг хийхэд хүргэсэн зүйлийг нь жигшүүлж, насаар нь харамсуулж амьдруулах нь зохист ял. Хамгийн гол нь жинхэнэ хэргийн эзэнд. Шийтгэл бол 5 секундын өвдөлт болох буудан хөнөөх, цахилгаан сандал дээр суулгаж алах биш, насан туршид нь ямар гэм нүгэл үлдсэнийг нь ухааруулах. Цаазын ял хэрэгтэнд хялбар, өвдөлтгүй, зовлон шаналалгүй үхэх боломжийг олгож байна. Үнэхээр ноцтой гэмт хэрэг үйлдсэн хэрэгтэнд энэ бол хүнд хэмжээний хариуцлага биш харин насан туршдаа зовж шаналахгүй, хариуцлага хүлээхгүй байх боломж. Онц ноцтой хэрэгтэнүүдийг бүрэн шийтгэж, хариуцлагийг мэдрүүлж, хэрэг үйлдэгдэх боломжтой орчин нөхцөлийг сайжруулсанаар гэмт хэрэгт гарах нөхцөл буурна. Хамгийн их үйлдэгддэг цаазын төрөл болох амь таслах тариа болон цахилгаан сандал дээр суух нь хорих ялаас илүү их мөнгөн зардал шаардагддаг, хохирогч гэр бүлийн улсад төлсөн татварыг гэмт хэрэгтний амь таслалтанд ашиглаж буй хэрэг.

Энэ мэт зүйлээс харвал, баттай тогтоогдсон гэмт хэрэгтэнг бүх насаар нь хорьж, хүнд хүчний ажил хийлгэж олсон мөнгийг нь өөрийн хэрэглээнд нь болон хохирогч талд өгж, бие физиологи сэтгэл санааны хувьд гэм буруугаа үхэн үхтэлээ үүрэх нь зохист ял. Харин хэлмэгдсэн бөгөөд буруу тогтоогдсон хүмүүсийг буцаан нийгмийн амьдралд оруулах ба жинхэнэ хэрэгтэнд нь амьдын тамыг үзүүлэх нь гэмт хэрэг бууруулахад нөлөөлнө. Мансууруулах бодис хэрэглэсэн, сэтгэцийн өвчтэй хүн юуг, яаж үйлдэх, ямар гэмт хэрэг хийснээ эрүүл ухаанаар санахгүй тул түүнээс нь ангижруулах ба харанхуй гудамж, бүүдгэр орчин зэргийг хот төлөвлөлтөнд оруулах зэргээр шийдэх нь олон улсын түвшинд хүний эрхийг хамгаалдаг, ардчилсан улс бүхий байхад туслахаас гадна тухайн улс дотоодын хүнд ноцтой гэмт хэргийг бууруулах арга юм. Эцэст нь бусдыг буруутган чичлэж яллахдаа бус, эргэн хэвийн амьдрах боломжоор дэмжин хүмүүжүүлэхдээ анхаарья!

Зөвлөмж

Сохроор цаазын ялыг дэмжих нь хүний эрхийн мэдлэггүй байгаагаа илтгэхээс гадна цаазаар авах нь гэмт хэргийг огт бууруулдаггүй, хэрэгтэнд зөв тохирсон ял биш тухай дээр дурдсан шалтгаан, нөхцөл байдал, үр дүнг анхаарч аливаа асуудлын утга учир, мөн чанарын судалсны дагуу дүгнэлт гаргаж байя!

НОМ ЗҮЙ

Дүгнэлт бичихэд ашигласан сурвалжууд:

<https://deathpenaltyinfo.org/policy-issues/costs>

https://files.deathpenaltyinfo.org/documents/pdf/FactSheet.f1605882308.pdf?fbclid=IwAR1-GRroDqBWrsb5FQYTEmy0xw-_YgyxITWsTdDpmCymE-cWxGQfUHC0XQ

pdf?fbclid=IwAR1-GRroDqBWrsb5FQYTEmy0xw-_YgyxITWsTdDpmCymE-cWxGQfUHC0XQ